



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 4 сарын 10 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Г Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн
байгуулах баримт бичгийг бүртгэх тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 254 дүгээр тогтоолоор баталсан “Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх тухай журам”-ын 2.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Райнос эссет менежмент монгол ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулж буй “Райнос монгол тогтмол орлогын сан” хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т үүрэг болгосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Райнос эссет менежмент монгол ҮЦК” ХХК /Бэ Санг Хёк/-д үүрэг болгосугай.

1/ Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг зохих журмын дагуу гүйцэтгэж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөн, мэргэжлийн ёс зүйтэй ажиллах;

2/ Үүсгэн байгуулсан “Райнос монгол тогтмол орлогын сан” хувийн хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, сангийн нэгж эрхийн танилцуулгад нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд Хороонд тухай бүр мэдэгдэн холбогдох баримт бичгийг бүртгүүлж ажиллах.

3. Тогтоол батлагдсанаас хойш ажлын 15 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН